



МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Төрийн цахим үйлчилгээний  
зохицуулалтын газрын үйл ажиллагааны  
стратеги, зохион байгуулалтын хөтөлбөр,  
бүтцийг шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32<sup>1</sup> дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2022 оны 69 дүгээр тогтоол, Засгийн газрын "Агентлаг байгуулах тухай" 2022 оны 499 дүгээр тогтоол, Засгийн газрын "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 2022 оны 487 дугаар тогтоол, Засгийн газрын "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 2023 оны 06 дугаар сарын 240 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хөтөлбөрийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын "Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хөтөлбөр, бүтцийг батлах тухай" 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Б.Батцэцэг)-д даалгасугай.

САЙД



Н.УЧРАЛ

1523010816

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын  
2023 оны 09 дугаар сарын 07-ны өдрийн  
1125 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН  
БҮТЦИЙН ХӨТӨЛБӨР

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1. Оршил

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (цаашид "Газар" гэх)-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-ийн зорилго нь хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй байдлаар хүргэх, зөвлөгөө, мэдээллээр хангах, үйл ажиллагааг боловсронгуй болгох, хяналт тавих чиг үүргийг зохицуулах үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

### 1.2. Үндэслэл

Энэ хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18<sup>4</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоол, 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 69 дүгээр тогтоол зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг тус тус үндэслэн боловсруулав.

### 1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль;
- Цахим гарын үсгийн тухай хууль;
- Кибер аюулгүй байдлын тухай хууль;
- Шуудангийн тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Холбогдох бусад хууль, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, стандарт.

### 1.4. Арга зүй


Хөтөлбөрийг боловсруулахдаа хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, төрийн захиргааны шинэчлэл, бусад улс орны ижил төстэй байгууллага болон өмнөх арга хэмжээний туршлагад үндэслэсэн арга зүйг ашиглалаа. Мөн салбарын тулгамдаж байгаа асуудал, стратеги, үйл ажиллагааны гол зорилт, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлоход хэрэглэдэг арга зүйг ашиглав.

### 1.5. Газрын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй байдлаар хүргэх, зөвлөгөө, мэдээллээр хангах, үйл ажиллагааг боловсронгуй болгох, хяналт тавьж, хариуцсан асуудлаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад бүх талын дэмжлэг үзүүлнэ.

## 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч

Газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр буюу үндсэн хэрэглэгч, үйлчлүүлэгчийг оновчтой, бүрэн тодорхойлох нь тус газрын үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамаарна.



Газрын үндсэн хэрэглэгч буюу үйлчлүүлэгч нь Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Засгийн газар, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд болно. Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан эх үүсвэр, үндсэн хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэнэ.

Газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон, тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

## ХОЁР. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

### 2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх, үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Газар нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй байна:

2.2.1 Мэдээллийн технологи, цахим систем ашиглан төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангах;

2.2.2 Төрийн үйлчилгээг хүргэхэд шаардлагатай бүрдүүлбэрийг цөөлөх, шат дамжлагыг бууруулах боломжийн талаар судлах;

2.2.3 Төрийн үйлчилгээний процесс, шат дамжлага, бүрдүүлэх бичиг баримтыг бууруулах талаар судлах, холбогдох арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

2.2.4 Цахим ур чадвар нэмэгдүүлэх шаардлагатай зорилтот бүлгийн иргэдэд төрийн үйлчилгээг хамгийн боломжит хувилбар, ойрын цэгээс авах боломжийг бүрдүүлэх.

### **2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго**

Газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулан, дараагийн шатанд гаргана.

### **2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт**

Газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлнэ:

2.4.1. Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх байршлын судалгаа хийж, үйлчилгээний цэгийг шинээр байгуулах, өөрчлөх, салбар, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах;

2.4.2. Төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

2.4.3. Үйлчилгээний салбар, нэгж, төрийн үйлчилгээний нэгдсэн системээр ирсэн хүсэлтийг шалгах, үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрлэж хариу өгөх;

2.4.4. Хэрэглэгчийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх, хэрэглэгчдийн үйлчилгээ авах мэдлэг ур чадварыг сайжруулах, сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлэх;

2.4.5. Төрийн үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах судалгаа хийх, дахин загварчлах, боловсронгуй болгох санал боловсруулж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

2.4.6. Төрийн үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх, үйлчилгээг хүргэх ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх.

### **2.5. Үйл ажиллагааны гол зорилт**

#### **2.5.1 Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:**

2.5.1.1. Төрийн үйлчилгээний хүртээмжийн талаар судалгаа хийж, үйлчилгээ үзүүлэх нэгжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

2.5.1.2. Төрийн үйлчилгээг оновчлох талаар судлах, хэрэгжүүлэх;

2.5.1.3. Салбар нэгжээр төрийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

2.5.1.4. Үйлчилгээний ачаалал, хүртээмжийн талаар судалгаа хийх, ачааллыг тэнцвэржүүлэх, хүртээмжийг сайжруулах;

2.5.1.5. Үйл ажиллагааны дотоод дүрэм, журам, стандартыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлах, биелэлтийг хангуулах.

#### **2.5.2 Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:**

2.5.2.1. Холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

2.5.2.2. Төрийн үйлчилгээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, гүйцэтгэлийг хянах.

#### **2.5.3 Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:**

2.5.3.1. Салбар, нэгжийн үйлчилгээ хүргэх ажилтны үйл ажиллагаанд нь хяналт тавих;

2.5.3.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр хүлээн авсан үйлчилгээний шийдвэрлэлтийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, хяналт тавих;

2.5.3.3. Салбар, нэгжийн үйлчилгээ хүргэх ажилтны шалгуур үзүүлэлтийг тогтоох;

2.5.3.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр хүлээн авсан хүсэлтийн шийдвэрлэлтэд тогтмол дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудыг мэргэжил

аргазүйгээр хангах, зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр, шаардлагатай арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх;

**2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:**

2.5.4.1. Төрийн үйлчилгээ шийдвэрлэлтийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, хариу өгөх сувгийг удирдах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх;

2.5.4.2. Хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээний талаар мэдлэг мэдээлэл өгөх зорилгоор агуулга бэлтгэх, хүргэх, түгээх;

2.5.4.3. Иргэдийн лавлагаа, санал гомдол, хүсэлтийг хүлээн авч анхан шатанд шийдвэрлэх, шийдвэрлэлтийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх стандарт, хэмжүүр үзүүлэлтийг боловсруулан, мөрдүүлэн ажиллах;

2.5.4.4. Төрийн үйлчилгээний гомдлыг бууруулах чиглэлээр холбогдох нэгжтэй хамтран ажиллах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшнийг дээшлүүлэх.

**2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дүгээр зорилтын хүрээнд:**

2.5.5.1. Үйлчилгээний дэд системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, сайжруулах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, хандах эрхийн удирдлагыг хэрэгжүүлэх;

2.5.5.2. Төрийн үйлчилгээ хүргэх сувгийг боловсронгуй, оновчтой болгох талаар судлах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

2.5.5.3. Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээ үзүүлэх бодлого, стратеги төлөвлөх;

2.5.5.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх талаар судлах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

2.5.5.5. Төрийн үйлчилгээ хүргэх сувгийг нэмэгдүүлэх талаар судалгаа хийх;

**2.5.6. Үйл ажиллагааны стратегийн 6 дүгээр зорилтын хүрээнд:**

2.5.6.1. Төрийн үйлчилгээ хүргэх ажилтныг сургах, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, мэргэшүүлэх;

2.5.6.2. Төрийн үйлчилгээ хүргэх ажилтны харилцааны соёлыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагаас сургалт авах, холбогдох бусад арга хэмжээг хамтран тогтмол зохион байгуулах;

**2.6. Үйл ажиллагааны зорилт**

Газрын үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

**ГУРАВ. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ**

**3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоог боловсруулахад баримтлах зарчим**

Газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав.

3.1.1. газрын үйл ажиллагааны стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх;

3.1.2. эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой байх;

3.1.3. үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх;

3.1.4. тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоосон байх;

3.1.5. үйлчилгээ үзүүлэхдээ мэргэшсэн чадамжтай байх.

### 3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон газрын үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус газрын үйл ажиллагааны бүтцийн дараах ерөнхий тогтолцооны загварыг боловсруулсан.



Газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулан, дараагийн шатанд гаргана.

Төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;


Үйлчилгээний салбар, нэгж, төрийн үйлчилгээний нэгдсэн системээр ирсэн хүсэлтийг шалгах, үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрлэж хариу өгөх;

Хэрэглэгчийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх, хэрэглэгчдийн үйлчилгээ авах мэдлэг ур чадварыг сайжруулах, сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлэх;

- Төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн хүн, хуулийн этгээдэд үр дүнтэй хүргэх, үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
- Холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- Төрийн үйлчилгээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, гүйцэтгэлийг хянах.

- Салбар, нэгжийн үйлчилгээ хүргэх ажилтны үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр хүлээн авсан үйлчилгээний шийдвэрлэлтийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, хяналт тавих;
- Салбар, нэгжийн үйлчилгээ хүргэх ажилтны шалгуур үзүүлэлтийг тогтоох;
- Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр хүлээн авсан хүсэлтийн шийдвэрлэлтэд тогтмол дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудыг мэргэжил аргагүйгээр хангах, зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр, шаардлагатай арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх;

- Төрийн үйлчилгээ шийдвэрлэлтийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, хариу өгөх сувгийг удирдах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх;
- Хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээний талаар мэдлэг мэдээлэл өгөх зорилгоор агуулга бэлтгэх, хүргэх, түгээх;
- Иргэдийн лавлагаа, санал гомдол, хүсэлтийг хүлээн авч анхан шатанд шийдвэрлэх, шийдвэрлэлтийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх стандарт, хэмжүүр үзүүлэлтийг боловсруулан, мөрдүүлэн ажиллах;
- Иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх;
- Төрийн үйлчилгээний гомдлыг бууруулах чиглэлээр холбогдох нэгжтэй хамтран ажиллах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшнийг дээшлүүлэх.



Хүн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээний бодлого, чиглэл, стратегийг тодорхойлон Цахим хөгжил, харилцаа холбооны яамны бодлоготой уялдуулан төрийн үйлчилгээг (лавлагаа, гомдол мэдээлэл, өргөдөл, нэг болон түүнээс олон шатлалт үйлчилгээ) стандартад нийцүүлэн хамгийн оновчтой хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээний бэлэн байдлыг хангах, иргэн төвтэй үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, үйлчилгээний чанар стандартыг мөрдүүлэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, цахим ур чадварыг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэхэд тус нэгжийн **газрын** зорилго оршино.

### 3.3. Зохион байгуулалтын бүтэц

Газрын үйл ажиллагааны стратегийн загвараас доор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд дараах үндсэн үүрэг, чиг үүрэгтэй: **үүргийг хэрэгжүүлэн ажиллана.**

#### 3.3.1. Захиргаа удирдлагын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:

Тус нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн захиргаа, үйлчилгээний албан хаагчдаас бүрдэх ба газрын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний талаар баталсан хууль тогтоомж, Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэр, дүрэм, журмыг дагаж мөрдөх, хэрэгжилтийг зохион байгуулах, газрын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжил, дотоод үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг



хариуцах ба гэрээний боловсруулалт, гүйцэтгэлийн хяналт, дүгнэлт, хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг нэгтгэн гаргах ажлыг зохион байгуулах, тайлагнах, дотоод ажлыг эрхлэх, газрын даргад шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах, газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээний талаар мэдээлэл, заавар, контент бэлтгэх, түгээх, гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, байгууллагын санхүүг эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Захиргаа удирдлагын газар нь Хамтын ажиллагаа, хэрэглэгчийн үйлчилгээний хэлтэстэй байна.

### **3.3.2. Систем нэгтгэл, сургалт хөгжлийн газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:**

Үйлчилгээ авахаар хандсан хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээний талаарх мэдээллээр хангах, хэрэглэгчийн лавлагаа, санал гомдол, хүсэлтийн гүйцэтгэлд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, холбогдох нэгжийг мэдээллээр хангах, төрийн үйлчилгээний гомдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа хийх, дахин загварчлах, сургалт хөгжлийг боловсронгуй болгох санал боловсруулж холбогдох байгууллага, нэгжтэй хамтран ажиллах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлэх, үндсэн, дэмжих систем болон бусад системтэй холбогдон ажиллах дэд системийг хөгжүүлэх, хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Систем нэгтгэл, сургалт хөгжлийн газар нь Систем нэгтгэлийн хэлтэс, Сургалт хөгжлийн хэлтэстэй байна.

### **3.3.3.Чанар хяналтын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:**

Төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам стандартыг мөрдөж байгаа эсэх, хэрэгжилтийг хангуулах, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай бүрдүүлбэрийг цөөлөх, шат дамжлагыг бууруулах боломжийн талаар судлах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, тайлан мэдээллээр холбогдох нэгжийг хангах, дотоод үйл ажиллагаа, үйлчилгээнд илэрсэн үл тохирол, алдааг хамаарах нэгжид мэдээлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### **3.3.4.Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:**

Төрийн үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг хангах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх байршлын судалгаа хийж, үйлчилгээний цэгийг шинээр байгуулах, өөрчлөх, салбар, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах, хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэх, чанар стандартыг мөрдүүлэх, сайжруулах, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, орон нутагт салбар, нэгжгүй төрийн захиргааны байгууллагын үйлчилгээг хариуцан хэрэгжүүлэх, ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, харилцааны соёлыг хэвшүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газар нь Нийслэл хариуцсан хэлтэс, Аймаг хариуцсан хэлтэс, Аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй байна.